



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
МОНГОЛ АРДЫН НАМ-д

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2020.07.28 № 294

танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.3, 37.5 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох аймгийн Монгол Ардын намаас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 2020 оны ээлжит сонгуульд оролцох аймгийн Монгол Ардын нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцүүлэн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт аймаг дахь Төрийн аудитын байгуулагад ирүүлж, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 37 дугаар зүйлийн 37.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох аймгийн Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020”, Өвөрхангай аймгийн нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, “Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг”, Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

015030568

D:\Auditin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Дүгнэлт

Аймгийн Монгол Ардын намын “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль”-д оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын заалт, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Аймгийн Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр / ... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Аймгийн сонгуулийн хороонд

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.ЛАМААЧИН

Өвөрхангай аймгийн Монгол Ардын Намын Хорооны тэргүүлэгчдийн
2020 оны 06-р сарын 18-ны өдрийн хуралдааны 12-р тогтоолын хавсралт

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМААС ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

**Уриа: Иргэдийнхээ орлогыг өсгөө
Илүү сайхан амьдарья**

Монгол Улсын “Алсын хараа 2050”, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, Өвөрхангай аймгийн нийгэм, эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг болон аймгийн салбаруудын дунд хугацааны хөтөлбөрүүдэд тулгуурлан 2020 оны аймгийн ИТХ-ын сонгуульд оролцох мөрийн хөтөлбөрийг боловсруулан сонгогч танд толилуулж байна.

Нэг. Эдийн засгийн өсөлт-Ажил, орлоготой иргэн

Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарыг эрчимтэй хөгжүүлж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэн, аймгийн нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг одоогийнхоос хоёр дахин өсгөнө.

- 1.1 Ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг боловсруулж, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, жижиг дунд үйлдвэрүүдийг шинээр байгуулах
- 1.2 Арвайхээр, Бат-Өлзий, Уянга, Богд, Хархорин суманд мал аж, ахуйн түүхий эдэд түшиглэсэн борц, сүү, сүүн бүтээгдэхүүн арьс шир, дайвар бүтээгдэхүүний үйлдвэр байгуулах
- 1.3 Ажлын байрыг нэмэгдүүлэх, өрхийн болон жижиг дунд үйлдвэрүүдийг хөнгөлөлттэй зээлээр дэмжих
- 1.4 Эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
- 1.5 Зүүнбаян-Улаан суманд цэвэр усны үйлдвэр байгуулах
- 1.6 Бэлчээрийн мал аж ахуйн цогц бодлого боловсруулан хэрэгжүүлж бэлчээрийн менежментийг сайжруулах замаар хөдөө аж ахуйн салбарын үр ашгийг нэмэгдүүлэх
- 1.7 Арвайхээрт малчдын мах, сүү цагаан идээ худалдан борлуулдаг худалдааны төвтэй болох
- 1.8 Иргэн бүрийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлж “Хуримтлалтай өрх” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.9 Анх удаа байр авч байгаа бага, дунд орлоготой иргэдэд урьдчилгаа төлбөргүйгээр, сумдад шинээр хашаа, байшин, сууц барьж буй иргэдийг 4-6 хувийн хүүтэй орон сууцны ипотекийн зээлд хамруулна.
- 1.10 Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх



18

Хоёр. Нийгмийн бодлого-Хүний хөгжил

Иргэдээ боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээнд адил тэгш, хүртээмжтэй хамрагдах нөхцөлийг бүрдүүлж, хүүхэд, гэр бүлийг дэмжсэн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.1 Боловсрол, соёлын салбарт

- 2.1.1 Арвайхээр, Уянга, Бат-Өлзий, Есөнзүйл, Хархорин, Төгрөг сумдад цэцэрлэгийн барилга шинээр барих, Арвайхээр, Хархорин, Богд, Нарийнтээл, Өлзийт, Есөнзүйл, Зүүнбаян-Улаан сумдын цэцэрлэгийг өргөтгөх, их засвар хийх, хувийн хэвшлийн цэцэрлэгийг дэмжин ажиллаж хамран сургалтыг 90 хувьд хүргэнэ
- 2.1.2 Арвайхээр хотод төвийн бүсийн “Хөгжим бүжгийн коллеж” байгуулах
- 2.1.3 ЕБС-ын 50-аас доошгүй хувьд нь хүүхэд, багачууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх спорт тоглоомын болон хөл бөмбөгийн талбай байгуулах
- 2.1.4 Арвайхээр суманд ЕБС-ын хичээлийн байр шинээр барих, Баянгол, Арвайхээр, Хужирт сумдын ЕБС-ын байрыг өргөтгөх, их засвар хийх
- 2.1.5 Арвайхээр суманд дотуур байр шинээр барих, Төгрөг, Сант, Есөнзүйл, Бат-өлзий, Өлзийт сумдын дотуур байрыг засварлах, өргөтгөх, эрүүл ахуй стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох
- 2.1.6 Өлзийт, Баян-Өндөр сумдын соёлын төвийг засварлах, өргөтгөх, сумдын соёлын төвийг тоног төхөөрөмжөөр хангах
- 2.1.7 ЕБС-ийн дотуур байр, СӨББ-ийн хатуу зөөлөн эдлэлийг үе шаттай шинэчлэх
- 2.1.8 Арвайхээр сумын ерөнхий боловсролын “Тэмүүлэл-Эрдэм” сургуулийг орчин үеийн шаардлагад нийцсэн спорт заалтай болгох Гучин-Ус сумын спорт зааланд их засвар хийнэ.
- 2.1.9 Томоохон ЕБС, СӨБ-д мах, ногооны зориулалтын хөргүүр бүхий агуулах барих
- 2.1.10 Арвайхээр сумын 11 дүгээр тусгай цэцэрлэгт усан эмчилгээ бүхий хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулагдсан стандартын барилгыг шинээр барих
- 2.1.11 Цэцэрлэгүүдийн гадна талбайн тохижилтыг стандартын шаардлагад нийцүүлэх, тоглоом сургалтын хэрэглэгдэхүүний хангалтыг үе шаттай шийдвэрлэх
- 2.1.12 Багшийн хөгжлийн цогц чадамжийг дээшлүүлэх “Багшийн хөгжлийн төв” байгуулах
- 2.1.13 Боловсролын байгууллагуудыг цахим тоног төхөөрөмж, камержуулалт, ухаалаг самбар, техник, хэрэгсэл, гал тогооны тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх
- 2.1.14 Боловсрол, соёлын салбарын гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлж, жил бүр тодорхой хэмжээний багш, уран бүтээлчид, удирдах ажилтнуудыг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах
- 2.1.15 Соёлын ажилтнууд, уран бүтээлчдийг хөрш зэргэлдээ болон бусад аймаг, улсад туршлага судлуулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр төрөл бүрийн сургалтад хамруулах, уран бүтээлийг таниулан сурталчлах
- 2.1.16 Орон нутгийн соёлын биет болон биет бус өвийн хадгалалт хамгаалалтыг нэмэгдүүлэх, түгээн дэлгэрүүлэх



19.

- 2.1.17 Орон нутгийн нүүдлийн ном соёлын үйлчилгээг өргөжүүлэн зарим соёлын төвүүдийг автомашинтай болгох
- 2.1.18 Хархорин сумын соёлын төвийн статусыг өөрчлөн соёл, аялал жуулчлалын төв болгон ажиллуулах
- 2.1.19 ЭрдэнэЗуу музейн үзмэрийн 80 орчим хувийг иргэдэд үзүүлэх боломжийг бүрдүүлэн, дижитал музейтэй болох.
- 2.1.20 Аймгийн ХДТеатр, сумдын Соёлын төвүүдийн материаллаг бааз, хүний нөөцийн хүчин чадавхыг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттай шийдвэрлэнэ.
- 2.1.21 ЕБС-д “Үдийн цай” хөтөлбөрийг үргэлжлүүлж, үдийн хоолоор үйлчлэх нөхцөлийг үе шаттайгаар бүрдүүлж, мэргэжилтэй боловсон хүчнээр хангаж, хүүхдэд шим тэжээл, амин дэмээр баялаг хоолоор үйлчилнэ.

2.2 Эрүүл мэндийн салбарт

- 2.2.1 Арвайхээр хотыг нэгдсэн эмнэлэгтэй болгох
- 2.2.2 ЭМГ-ын нийгмийн эрүүл мэндийн хэлтсийг ТӨВ болгон өргөтгөж, нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх
- 2.2.3 “Эрүүл шүд-Эрүүл монгол” хүүхэд хөтөлбөрийг үргэлжлүүлэх
- 2.2.4 Сумын төв болон хөдөөгийн хүн амыг баталгаат ундны усаар хангах, ундны усны хатуулгыг бууруулах арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлнэ.
- 2.2.5 Аймгийн ЭМГ-ын эмийн агуулахыг шинээр барих, Бат-Өлзий сумын ЭМТ-ийн өргөтгөл, их засвар, Хархорин, Хужирт, Богд, Сант, ББУ, Өлзийт, Гучин-ус, Баян-Өндөр сумын ЭМТ-ийн их засвар, Уянга, Бат-Өлзий, Баянгол, Өлзийт, Гучин-Ус сумын эмчийн байр шинээр барих, Хархорин, Хужирт, Бат-Өлзий, Бүрд сумын эмчийн байрны их засвар, бүх сумдад эрүүл мэндийн MOBILE технологийг нэвтрүүлэх, БОЭТ-д шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, ЭМБ-уудийн Түргэн тусламжийн Авто машины парк шинэчлэлтийг хийнэ. БОЭТ-ийн хүүхдийн эмнэлгийн хатуу зөөлөн эдлэл, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах
- 2.2.6 Хөдөөгийн багийн эмч нарыг унаатай болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, нэн шаардлагатай нарийн мэргэжлийн эмч нарыг БОЭТ-д ажиллах тохиолдолд байр орон сууцаар хангах, ЭМ-ийн салбарын гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлж, жил бүр тодорхой хэмжээний эмч, сувилагч, удирдах ажилтнуудыг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах
- 2.2.7 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, архины хэрэглээг багасгах, хорт зуршлыг арилгах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшил төрийн бус байгууллагыг дэмжиж ажиллана.
- 2.2.8 Сумдын ахмадын өргөөг чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмжөөр хангах
- 2.2.9 Өрхийн Эрүүл Мэндийн Төвүүдийн үйл ажиллагааг сайжруулж, өдрийн болон гэрийн эмчилгээ, асаргаа сувилгаа, сэргээн засах, хөнгөвчлөх үйлчилгээний чиглэлээр өргөжүүлнэ.



20.

Гурав. Төрийн үйлчилгээ

Төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй, шударга үйлчилдэг тогтолцоог бий болгоно.

- 3.1 Төрийн үйлчилгээг шуурхай болгох лавлагаа мэдээллийг сумаасаа авах боломж нөхцөлийг бүрдүүлсэн дэвшилтэт технологи нэвтрүүлж, цахим хэлбэрт шилжүүлэх
- 3.2 Есөнзүйл, Богд, Хайрхандулаан, Тарагт сумдын ЗДТГ-ын байрыг шинээр барих, Баянгол, Төгрөг, Сант сумдын ЗДТГ-ын байрыг өргөтгөх, засварлах, Төрийн байгууллагуудын автомашины парк шинэчлэлийг үе шаттайгаар хийх
- 3.3 Төрийн алба хаагчдын ажлын байранд тавигдах шаардлагын дагуу аттестатчилж, мэргэжил, ур чадвар, ёс зүйг үнэлж, хариуцлагыг өндөржүүлэх.
- 3.4 Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэн өргөтгөж, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлнэ.
- 3.5 Төрийн байгууллагын бүх салбарт хууль дээдлэх ёсыг бодитой хэрэгжүүлж, төрийн албан хаагчдыг ашиг сонирхлын зөрчил, авлигад өртөхгүй байх, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 3.6 Аймгийн хэмжээнд шаардлагатай зарим багуудад багийн төвийг шинээр барих, багийн дарга нарыг унаагаар хангах.
- 3.7 Иргэд, хувийн хэвшил, аж ахуйн нэгжид хийх төрийн хяналт шалгалтыг багасгаж зөвлөн туслах үйлчилгээг нэмэгдүүлж, хэвлэл мэдээллийн байгууллагыг чадавхижуулах.
- 3.8 Төрийн байгууллагуудын компьютер техник, хэрэгслийн шинэчлэл хийх
- 3.9 Эрх нь зөрчигдсөн хүүхэд, эмэгтэйчүүд, гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээ, хүүхдийн тусламжийн утасны сүлжээг олон улсын стандартад нийцүүлэн өргөжүүлж, бат бөх гэр бүлийг төлөвшүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах.
- 3.10 Төрийн худалдан авах ажиллагааны шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, олон нийтэд ил тод, нээлттэй явуулна.
- 3.11 Хөдөлмөрийн мөлжлөгийг бууруулах чиглэлээр ажиллах орон тооны бус зөвлөл байгуулан ажиллана.
- 3.12 Хөдөөгийн малчид болон зарим сумдын үүрэн холбооны сүлжээг өргөтгөх / Мобиком, Юнител, Жи-мобайл, Скайтэл/

Дөрөв. Хүнс хөдөө ахуй, Хөдөлмөр эрхлэлт

Хүнс, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарыг эрчимтэй хөгжүүлж өрх бүрийг үйлдвэрлэгч болгоно.

- 4.1 Арвайхээрт малчны хорооллыг байгуулж, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх;
- 4.2 Мал эмнэлгийн үйлчилгээг дэмжиж, чанарыг сайжруулж, малын эмчийн тоог нэмнэ.
- 4.3 Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрийг бодлогоор дэмжих;
- 4.4 Газар тариалангийн салбарт орчин үеийн өндөр хүчин чадалтай техник, технологи нэвтрүүлж шинэчлэл хийх;
- 4.5 Дайргын гол бүс нутагт дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэж, услалтын системийг өргөжүүлэх;



21.

- 4.6 Сумдад хүнсний ногооны төрөлжсөн зоорь, өвөл, зуны хүлэмж, хүнсний ногоог даршлах боловсруулах үйлдвэр, цех бий болгох, механикжсан, автоматажсан зоорь, худалдааны төвүүдийг бий болгох
- 4.7 Малыг ээмэгжүүлэн бүртгэлжүүлж, эрүүлжүүлэх, зах зээлд /экспорт/ давуу эрхтэйгээр нийлүүлэх боломжийг бүрдүүлнэ;
- 4.8 “Баянгол омог”-ийн хонин сүргийг “Баянгол үүлдэр” болгох ажлыг үргэлжлүүлэх;
- 4.9 “Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөцийн ашиглалт, экспортыг нэмэгдүүлэх;
- 4.10 Олон улсын жишигт нийцсэн эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан мах экспортлох;
- 4.11 Ноос, ноолууран бүтээгдэхүүний жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- 4.12 Бүс нутагт үржүүлэх баталгаажсан үүлдэр омгийн малаас сайн чанарын хээлтүүлэгч, хээлтэгч худалдан авч, үндсэн сайжруулагчаар ашиглах, ердийн болон зохиомол хээлтүүлгийн аргаар үржлийн ажил явуулж тоо толгойг нэмэгдүүлэх, тархалтын хүрээг тэлэх;
- 4.13 Гучин-Ус сумын Монголын хоолойн тэмээ, Нарийнтээл сумын Тээлийн улаан нутгийн шилмэл хэвшлийн ямаа, Уянга сумын Таац, Жаргалант, Шуранга, Ар царамын сарлагийн аж ахуй, биологийн онцлог, ашиг шимийн түвшин тогтоох судалгаа хийж баталгаажсан үүлдэр, омог, хэвшлийн мал бий болгох;
- 4.14 Аймаг, сумдын өвсний аюулгүйн нөөцийг бүрдүүлэхэд хямд үнэтэй, чанартай өвсийг тогтмол бэлтгэн нийлүүлэх, өөрийн эзэмшлийн хадлангийн талбайтай иргэн, аж ахуй нэгжид техник, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах
- 4.15 Мал үржүүлэг, технологийн нэгжийг сум бүрт байгуулж, ажил үйлчилгээг дэмжих, хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрт хамруулах, чадвахуулах;
- 4.16 Аймгийн тариалангийн бүс нутаг болон хүн ам олноор суурьшсан төв суурин газруудыг дагуулж өндөр ашиг шимтэй мах, сүүний, хосолмол үхрийн аж ахуй болон гахай, тахай, зөгийний аж ахуйг хөгжүүлэх;
- 4.17 “Бэлчээр ашиглалтыг сайжруулах аймгийн журам” гаргаж бэлчээрийн менежментийг сайжруулах арга хэмжээ авч, үлийн цагаан оготноос хамгаалах, усжуулах, бэлчээрийг хаших, сэлгэж, өнжөөх, хуваарьтай ашиглах;
- 4.18 Малын тэжээлийн ургамал тариалалтыг нэмэгдүүлж, иргэд, аж ахуй нэгжид малын тэжээл тариалах талбайг шинээр олгох, тоног төхөөрөмж худалдан авах болон үйл ажиллагаа явуулахад нь хөнгөлттэй зээлээр дэмжих, төсөл хөтөлбөрт хамруулах;
- 4.19 Малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх чиглэлээр тоног төхөөрөмж, багаж техник хэрэгсэл хийж буй иргэн аж ахуй нэгжийг дэмжих, сурталчлах, малчдыг чадваржуулах, давтан сургах, залуу халааг бэлтгэх болон тэднийг гадаад, дотоодын туршлага судлуулах арга хэмжээнд зохион байгуулалттай хамруулах;
- 4.20 Хөдөө аж ахуйн салбарын мэргэжилтнүүдийг давтан сургах, мэргэшүүлэх, гадаад, дотоодын сургалтанд хамруулах.
- 4.21 Мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах, мал сүргийг халдварт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, угаалга, туулгад бүрэн хамруулах
- 4.22 Хархорин суманд Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр Хужирт, Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий сумдад Хөдөө аж ахуйн агро парк байгуулах



- 4.23 Бэлчээрийн даац төлөв байдлын үнэлгээнд тулгуурлан отрын бүс нутаг, нөөц бэлчээрийг нэмэгдүүлж, оновчтой ашиглах, усан хангамжийг сайжруулах, хашиж хамгаалах, нөхөн сэргээхэд малчид, иргэдийн санаачилгыг дэмжиж ажиллана.
- 4.24 “Нэг сум- нэгдсэн мал эмнэлэг”-ийн үйл ажиллагааг сайжруулж, дэмжлэг үзүүлж, малын гоц болон халдварт өвчнийг бууруулах, малын эрүүл мэнд, эрүүл хүнстэй байх бодлогыг барьж, мал эмнэлгийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагааг тогтмолжуулах.
- 4.25 Хархорин суманд гурил тэжээлийн томоохон үйлдвэрийг байгуулж, аймгийн малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, фермерийн аж ахуй хөгжүүлнэ
- 4.26 Мал, амьтны гаралтай халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах замаар мал, амьтны гоц халдварт өвчингүй тайван бүс болгох.
- 4.27 Сумын нийт мал сүргийн бүтцийг боловсронгуй болгож, бэлчээрийн даацад тулгуурлан сүргийн тоо толгойг зохистой хэмжээнд барьж, чанартай малтай малчдыг урамшуулах тогтолцоог бий болгох, залуу малчдыг бэлтгэх
- 4.28 Мал маллах сонирхолтой цөөн малтай өрх болон залуучуудыг төсөл хөтөлбөрт хамруулах.
- 4.29 Малыг хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг сайжруулах, малыг коджуулах технологийг нэвтрүүлнэ.

Тав. Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхай

Аялал, жуулчлалын салбарыг аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбаруудын нэг болгон, байгаль орчинд ээлтэй ногоон эко аймаг болж, агаарын бохирдолыг 50-аас дээш хувиар бууруулна.

- 5.1 Арвайхээр хот болон томоохон сумын төвийн гэр хорооллын айл өрхүүдийг сайжруулсан түлшээр хангаж агаарын бохирдлыг 50 хувь бууруулах
- 5.2 Арвайхээр хотын ногоон байгууламжийн хэмжээг 50 хувь нэмэгдүүлэх
- 5.3 Сумдын Гэр хороолол, багуудад иргэд чөлөөт цагаа өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэн байгуулах
- 5.4 Аялал жуулчлалыг аймгийн тэргүүлэх салбарын нэг болгож, сумдын онцлох нөхцөл байдалтай уялдуулан аялал жуулчлал эвент арга хэмжээнүүдийг тогтмолжуулах /сарлагийн, тэмээний, хонины, адууны, айрагны, торгоны замын, мөсөн шагайны гэх мэт/, өвөл зуны аялал жуулчлалыг хөгжүүлж, жуулчдын тоог одоогийн түвшнээс 2 дахин өсгөж, жуулчдаас орох орлогыг нэмэгдүүлэх
- 5.5 Шатсан болон өвчилсөн ойг нөхөн сэргээх мод бут тарих ногоон байгууламжийг нэмэгдүүлэх
- 5.6 Усны нөөцийг нэмэгдүүлэх, булаг шандны эхийг хамгаалах, нөхөн сэргээх, хөв цөөрөм байгуулах ажлыг эрчимжүүлэх, Дэлгэрэх гол төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх
- 5.7 Арвайхээр суманд хог хаягдлыг дахин боловсруулах бага оврын үйлдвэр, сумдад цех байгуулах
- 5.8 Ойжуулалт мод үржүүлгийн мэргэжлийн байгууллага, иргэнийг дэмжих, төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, мод модон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих
- 5.9 Аялал жуулчлал, дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалыг хөгжүүлэх



- 5.10 Амралт, рашаан сувилуулалуудыг түшиглэсэн хөдөө аж ахуйн агро парк бий болгох
- 5.11 Олон улсын өвөл, зуны спорт сургалтын цогцолбор төв байгуулах.
- 5.12 Орхоны хөндийн аялал жуулчлалын маршрут: Элсэн тасархай, Их, бага Монгол уул - Ширээт цагаан нуур - Монгол орны төв цэг, Хархорин-Эрдэнэзуу - Шанхын хийд - Хужирт сум, Үүртийн тохой - Төвхөн хийд, Улаан цутгалан - Бат-Өлзий сум
- 5.13 Тусгай сонирхлын аяллын маршрут: Найман нуур
- 5.14 Говийн болон баруун бүсийн сумдын аяллын маршрут: Арвайхээр, Мазар хотын туурь - Өөш шахлага - Арц богдын нуруу - Зүүн богд уул - элсний эмчилгээ - Таацын цагаан нуур - Өшгөгийн их залаа - Өнц шилүүстэй - Шаргын тасархай, Шаамын рашаан - Хубилай хааны цэргийн хотын туурь, Найман нуур, Арвайхээр сум
- 5.15 Өндөр гэгээн Занабазарын түүхэн замналаар аялах маршрут: Элсэн тасархай – Их, бага Монгол уул - Ширээт цагаан нуур - Монгол орны төв цэг, Өвгөн суварга - Сэрүүн булаг-Сангийн далай - Арвайхээр цэцэрлэгт хүрээлэн.
- 5.16 “Хархорин XIII зуун” төслийг боловсруулан хэрэгжүүлж эзэнт гүрний нийслэл Хархорум хотын туурийг ил музей болгох.
- 5.17 Хужирт, Бат-Өлзий, Тарагт сумдын халуун рашаан, Баруунбаян-Улаан сумын элсний эмчилгээг түшиглэн жуулчдад зориулсан эмнэлэг, амралт, ардын уламжлалт эмчилгээ, үйлчилгээний газрууд,
- 5.18 Арвайхээр, Хархорин сумдад Өвөрхангайн брэнд бүтээгдэхүүний дэлгүүр, худалдааны төвүүдийг бий болгох.
- 5.19 Аймгийн музейн үзмэрийг шинэчлэн баяжуулж, Их хаадын үеийн урлагийн үзүүлэх тоглолт галерейг зохион байгуулах.
- 5.20 Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицийн үйл ажиллагааг тогтмолжуулан, ган хуурайшилтын эрсдэлийг бууруулах
- 5.21 Аймгийн Хөгжимт драмын театрын үйл ажиллагааг аялал жуулчлалтай холбон өргөжүүлж, Эрдэнэзуу музейн дэргэд түүхэн хэлбэртэй зуны театр байгуулж, орон нутгийн музейд их хаадын үеийн урлагийг үзүүлэх галерейг бий болгох
- 5.22 Гамшгийн голомтод ажиллах алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж, авто машин, техник тоног төхөөрөмжөөр бүрэн хангана.
- 5.23 Монгол улсын төв цэгийн “ГАЛ ГОЛОМТ ЦОГЦОЛБОР” ийг байгуулах
- 5.24 Зарим сумдыг бохир соруулах автомашинтай болгох
- 5.25 Хархорин суманд Аялал жуулчлалын гудамж байгуулах, цэцэрлэгт хүрээлэн бий болгох
- 5.26 Уянга сум Найман нуур чиглэлийн аялал жуулчлалын авто замыг сайжруулах
- 5.27 Төв суурин газрын айл өрхүүдийн хөрсний бохирдлоос сэргийлэх био жорлонтой болгох;

Зургаа. Хот байгуулалт, дэд бүтэц

Арвайхээр хотод дулааны цахилгаан станцыг ашиглалтад оруулж, томоохон сумдын төвийн инженерийн шугам, сүлжээ дэд бүтэцийн байгууламжыг шийдвэрлэнэ.

- 6.1 Баянтээгийн уурхайн ашиглалтын нөөцийг нэмэгдүүлэн, 36 МВт-ийн цахилгаан станц барьж, сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийг өргөтгөж өөрийн болон зэргэлдээх аймгуудын түлшний хэрэгцээг хангаж, агаарын бохирдлыг бууруулна.

- 6.2 Сумдын төвийн доторх хатуу хучилттай замын сүлжээг нэмэгдүүлэх
- 6.3 Орон нутгийн чанартай авто замд гүүр шинээр барих, их засвар хийх / Бат-Өлзий сумын Улааны голын гүүр, Хархорин мааньтын хөнөгийн гүүр, ЗБУ сумын Нургийн гүүр/
- 6.4 Сумдын төвийг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээ, авто болон явган хүний зам, замын гэрэлтүүлэг, ногоон байгууламж, үерийн суваг, гэр хорооллын хэсэгчилсэн төлөвлөлтүүдийг сумын онцлогт тохируулан үе шаттай хэрэгжүүлнэ.
- 6.5 Бат-Өлзий суманд байгалийн хүрмэн чулууг ашиглан барилгын материал, зам талбайн хавтан үйлдвэрлэх.
- 6.6 Сумдын төвүүдийн хяналтын камерийн системийг нэмэгдүүлэх.
- 6.7 Аймгийн төвийн эрчим хүчний шөнийн тарифыг тэглэх
- 6.8 Хархорин сумыг аялал жуулчлалд түшиглэсэн жишиг хот болгон хөгжүүлж, нисэх буудлыг олон улсын 4C зэрэглэл бүхий агаарын хөлөг хүлээн авах хүчин чадалтай аэродром, зорчигч үйлчилгээний цогцолбор олон улсын нисэх буудал болгоно.
- 6.9 Арвайхээрт шинээр дулааны станц барьж, аж ахуйн нэгж байгууллага, гэр хороолол, орон сууцыг холбоно.
- 6.10 Монгол Улсын төв хэсэгт байрлах байршлын давуу талаа ашиглан хангайн бүсийн аймгуудыг хойноос урагш, баруун аймгууд, Улаанбаатар хот болон бусад аймгуудыг холбосон ХАА-н түүхий эд ба бүтээгдэхүүн, бөөний худалдаа, агуулах, транзит тээврийн төв болгон хөгжүүлнэ.
- 6.11 Барилгын материалын үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлж, баруун бүс, хангайн бүсийг холбосон барилгын материалын худалдааны төв болгоно.
- 6.12 Аймгийн уул уурхайн ордуудад геологийн нарийвчилсан хайгуул хийж, нөөцийг шинэчлэн тогтоож, ордуудыг эдийн засгийн эргэлтэнд оруулна.
- 6.13 Арвайхээр хотыг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, аялал жуулчлал, барилга, барилгын материалын худалдаагаар баруун болон хангайн бүсийг хангасан худалдаа үйлчилгээ тээвэр ложистикийн төв, Хархорин хотыг Монгол орны аялал жуулчлал, түүх соёлын төв хот болгон хөгжүүлж, бусад сумдыг дээрх хоёр хотыг түшиглэн хөгжүүлнэ.
- 6.14 Хужирт, Хайрхандулаан суманд нийтийн цэвэрлэх байгууламжийг шинээр барих
- 6.15 Арвайхээр, Хархорин, Хужирт, Бат-Өлзий сумдын доторх хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөн, "Хужирт - Төвхөн хийд - Улаанцутгалан", "Хархорин - Хужирт - Арвайхээр", "Арвайхээр - Баянгол - Сайхан-Овоо - Цогт-Овоо", "Арвайхээр - Гурван тэс - Шивээхүрэн" чиглэлийн авто замуудыг шинээр барих зураг төслийг боловсруулан, барьж эхлэх, Улаанбаатар Арвайхээрийн чиглэлийн 60 км авто замын шинэчлэл хийнэ.
- 6.16 Арвайхээр сумын хуучин орон сууцнуудыг дахин төлөвлөж, барилгын гадна фасад, дээвэр, орцыг шинэчлэн засварлаж, орчны тохижилтыг хийж, хэрэглээний халуун усаар бүрэн хангах.
- 6.17 Томоохон сумын төвүүдэд цэвэр, бохир усны шугам сүлжээг бий болгох, өргөтгөх
- 6.18 А0301, А0302 улсын чанартай авто замтай ойролцоо сумдыг холбох, зураг төсвийг хийлгэх, барьж эхлүүлэх /Бүрд, Есөнзүйл, Өлзийт, Зүүнбаян-Улаан, Тарагт, Хайрхандулаан/
- 6.19 Хужирт, Бат-Өлзий сум хоорондох 50 км хатуу хучилттай замын зураг төсвийг хийлгэх, барьж эхлүүлэх



Handwritten signature and initials, possibly indicating approval or completion of the document.

- 6.20 Бат-Өлзий сумын Орхон голын гүүрнээс Цагаан голын гүүр хүртэлх сайжруулсан замыг Цагаан голын гүүрнээс сумын төвийн ар талын Могойтын голын гүүр хүртэлх сайжруулсан зам, Үүртийн тохой гүүрийг барьж дуусгах, сумын төвийн сайжруулсан замыг асфальтлах
- 6.21 Арвайхээр, Хархорин сумын 0,4кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг кабелиар сольж ухаалаг тоолууртай болгох
- 6.22 Арвайхээр сумын гэр хорооллыг орон сууцжуулж цэвэр бохир, дулаанд холбох зураг төсвийг хийлгэх эхлүүлэх
- 6.23 Арвайхээр болон томоохон сумын төвүүдэд түрээсийн болон нийтийн орон сууц барих
- 6.24 Томоохон сумдын төвийн цэвэр усны болон ариутгах татуургын нэгдсэн байгууламж, дулааны төвлөрсөн системийг бий болгон, аж ахуй нэгж, айл өрхийг холбогдох нөхцөлийг бүрдүүлнэ.
- 6.25 Вангийн овоо багийн хот хоорондын засмал зам, Ганган орхон баг 3-р хорооны өргөн чөлөөний засмал зам, Эрдэнэ толгой баг 6-р хорооны өргөн чөлөөний засмал зам дагуу цэвэр бохир, дулааны шугам татах;
- 6.26 Эрдэнэ зуу гудамжны төм замаас 60 айлын хойд талын шинэ засмал зам хүртлэх 600 метр засмал зам тавих;
- 6.27 Сумдын төрийн байгууллагуудын цэвэр, бохир усны шугам дэд бүтцийг үе шаттайгаар байгуулах

Долоо. Хууль эрх зүйн бодлогын хүрээнд

Иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд онцгой анхаарч ажиллана.

- 7.1 Суманд бүртгэл, мэдээллийн онлайн системийг бүрэн нэвтрүүлж, иргэний эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг сумандаа чирэгдэлгүй үзүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 7.2 Гэмт хэргийн гол шалтгаан болсон архидалт, гэр бүлийн хүчирхийлэл, амьдралын буруу зуршил нийгмийн сөрөг үзэгдлүүдтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, үнэт баялаг монгол ёс заншил ухамсрыг хүүхэд, залуучуудад төлөвшүүлж, зөв хүмүүжил олгох ажлыг иргэд, төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор хэрэгжүүлж, иргэдийн амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 7.3 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, орон байр, эд хөрөнгийн хулгай илрүүлэх, таслан зогсоох, нийгмийн хэв журмыг хангах үйл ажиллагааг сайжруулах зорилгоор хяналтын камерын системийг нэмэгдүүлнэ.
- 7.4 Олон нийт, цагдаагийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах ажлын хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, орон байрын хулгайн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг хангах чиглэлээр үйл ажиллагааг явуулж байгаа олон нийтийн зөвлөл, нөхөрлөл, бүлгэмийн үйл ажиллагааг бүх талаар дэмжиж ажиллана.
- 7.5 Шүүхийн шинжилгээний алба, Хужирт сумын Цагдаагийн тасгийг шинэ байртай болгож, хуулийн байгууллагуудын ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО



Handwritten signatures and initials.